



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 239

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.б, д, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 20'000'000 /хорин сая/ төгрөгийн анхны өртөгтэй, 766'670 /долоон зуун жаран зургаан мянга зургаан зуун дал/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Прадо маркын автомашин, 2'170'800 /хоёр сая нэг зуун далан мянга найман зуу/ төгрөгийн анхны өртөгтэй элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн тракторыг тус тус аклан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Тракторын худалдах үнийн доод хязгаарыг 500'000 /таван зуун мянга/ төгрөгөөр, автомашины худалдах үнийн доод хязгаарыг 5'000'000 /таван сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга Ч.Ганбаярт даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ